

## ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор “Алсын хараа- 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлагдаж, хүний хөгжил төвтэй хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж байна.

Энэ бодлогын хэрэгжилтийг хангах зорилгоор Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” болон 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т олон улсад өрсөлдөх чадвартай боловсролын хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлэх зорилтыг тус тус дэвшүүлсэн.

Зорилтын хүрээнд хэрэгжилтийг хангахад боловсрол, сургалт, эрдмийн зэрэг, цолыг дэлхийн улсуудтай харилцан хүлээн зөвшөөрөх явдал нэн чухал байна.

Анх 1975 оны 6 дугаар сард Латин Америк болон Карибд дээд боловсролын сургалт, диплом, эрдмийн зэрэг, цолыг хүлээн зөвшөөрөх тухай бүс нутгийн конвенцыг баталснаар дээд боловсролын сургалт болон эрдмийн зэрэг, цолыг харилцан хүлээн зөвшөөрөх үйл ажиллагааг зохицуулах хэм хэмжээг тодорхойлсон бөгөөд үүнээс хойш дэлхийн бүх бүс нутгийг хамруулсан ижил төрлийн 11 Конвенцыг баталсан байна.

“Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенц” нь 2019 оны 11 дүгээр сард ЮНЕСКО-ийн Ерөнхий бага хурлын 40 дүгээр чуулганаар батлагдсан нь Нэгдсэн үндэстний байгууллагаас дээд боловсролын салбарыг хамарсан анхны дэлхийн хэмжээний гэрээ болсон байна.

Конвенцод нэгдэх нь ЮНЕСКО-ийн гишүүн орнуудад нээлттэй.

Конвенцын XVIII дахь хэсэгт заасны дагуу 2022 оны 12 дугаар сарын 20-нд 20 дахь орон уг конвенцыг соёрхон баталснаар 2023 оны 03 дугаар сарын 05-нд дэлхийн гэрээ хүчин төгөлдөр болсон.

2023 оны 05 дугаар сарын байдлаар Япон, Франц, Норвег, Швед, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс, Австрали, Эстони, Литва, Армени зэрэг дэлхийн 22 улс<sup>1</sup> энэхүү гэрээнд нэгдэн ороод байна.

Уг конвенц нь нэгдэн орсон улс орнуудын их, дээд сургуулиудын боловсрол, сургалтын үр дүн, зэрэг, цолыг ил тод, шударгаар хүлээн зөвшөөрөх, суралцагчдад бусад орны их, дээд сургуулиудад үргэлжлүүлэн суралцах, хөдөлмөр эрхлэх, зайн хэлбэрээр суралцах, эзэмшсэн мэргэшлээ хүлээн зөвшөөрүүлэх боломжийг олгодог.

Конвенц нь зургаан бүлэг, 25 зүйлтэй.

Нэгдүгээр бүлэгт дээд боловсролын нэр томъёоны тодорхойлолтыг, хоёрдугаар бүлэгт конвенцын зорилго, гуравдугаар бүлэгт дээд боловсролын эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх үндсэн зарчим, дөрөвдүгээр бүлэгт конвенцын гишүүн улсын үүрэг, тавдугаар бүлэгт бүтэц ба хамтын ажиллагаа, зургаадугаар бүлэгт гишүүн улсууд соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, конвенцод нэгдэх, хүчин төгөлдөр болох, конвенцын гишүүн улсууд болон конвенц, бусад гэрээ хэлэлцээрийн талуудын хоорондын харилцаа, холбооны, эсвэл нэгдмэл бус үндсэн

<sup>1</sup> <https://www.unesco.org/en/higher-education/global-convention>

хуультай тогтолцоо, конвенцоос татгалзах, эх хадгалагчийн чиг үүрэг, конвенцод нэмэлт өөрчлөлт оруулах харилцаа, Нэгдсэн үндэстний байгууллагад бүртгүүлэх, албан ёсны эх хувийг тодорхойлох зэрэг төгсгөлийн заалтуудыг оруулсан.

ЮНЕСКО-гийн гишүүн улс энэ конвенцыг өөрсдийн үндсэн хуулийн болон хууль тогтоомжийн холбогдох журмын дагуу баталж, соёрхон баталсан тухай баримт бичгийг ЮНЕСКО-ийн Ерөнхий захиралд хадгалуулах тул гарын үсэг зурах шаардлага байхгүй болно.

“Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенц”-ын асуудлыг 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, хуралдааны 52 дугаар тэмдэглэлд заасны дагуу Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр хүргүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын Байнгын хорооны 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг зөвшилцөх асуудлыг дэмжсэн.

Иймд Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенц”-ыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн дэмжээд Улсын их хуралд өргөн мэдүүлэхээр тогтсон байна.

Хуулийн төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засаг, хууль эрх зүйн сөрөг үр дагавар үүсэхгүй бөгөөд конвенцод нэгдэн ороход эдийн засгийн ямар нэг үр дагавар, нөлөө байхгүй. Уг конвенцод нэгдэн орж, хэрэгжүүлэхэд ямар нэг төлбөр шаардахгүй юм.

Конвенцод нэгдэн орсноор дээд боловсролын салбар дахь олон улсын харилцан ашигтай хамтын ажиллагаа бэхжиж, бүс нутаг хоорондын санал, бодлого, инновац дэмжигдэх, дээд боловсролын байгууллага, тогтолцоонд чанарын баталгаажуулалтын тогтолцоо, соёл төлөвших, чанарын баталгаажуулалт найдвартай, уялдаа холбоо, чадавх бэхжих болно.

Түүнчлэн дээд боловсролын мэргэшлийг шударга, ил тод, ялгаварлан гадуурхалгүйгээр хүлээн зөвшөөрч, дээд боловсрол эзэмших боломжийг олгож, цаашдын суралцах, ажилд орох боломжийг олгодог нийтлэг зарчмууд хэрэгжинэ.

Мөн зайны сургалтаар олж авсан иргэний мэргэшил, өмнө нь суралцсан, суралцах хугацааг хүлээн зөвшөөрөх, иргэд насан туршийн боловсрол, сургалтад хамрагдах боломж бүрдэнэ.

Хуулийн төсийг баталж, конвенцод нэгдэн орсны дараа Боловсрол, шинжлэх ухааны яамнаас дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллана:

1.Конвенцыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг хангана;

2.Боловсролын ерөнхий хуулийн хэрэгжилтийн хүрээнд дээд боловсролын тогтолцоо, эрдмийн зэрэг, чанарын баталгаажуулалт, эрдмийн зэргийн цар хүрээний тухай холбогдох үнэн зөв мэдээллийг хүртээмжтэй байлгах үүднээс магадлан итгэмжлэл хийх эрхийг дотоодын байгууллагад олгох, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 7.9-д заасны дагуу гадаадын хуулийн этгээдэд зөвшөөрөл олгох, гадаад улсын болон олон улсын эрх бүхий байгууллагатай хамтран магадлан итгэмжлэл хийх, олон улсад магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийг баталгаажуулах, бүртгэх үйл ажиллагааг Боловсролын чанарын баталгаажуулалт магадлан итгэмжлэлийн байгууллага хэрэгжүүлж, олон улсын гэрээ, хэлэлцээрийн хүрээнд боловсролын зэрэг, баримт бичгийг харилцан хүлээн зөвшөөрөх, судалгаа, үнэлгээ хийх, баталгаажуулах сан бүрдүүлнэ;

3.Монгол Улс, Засгийн газар хоорондын Бага хурлын сүлжээнд нэгдэж, бүс нутгийн хороодтой хамтран ажиллана.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Олон улсын гэрээний тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал болон бусад хуульд заасан Монгол Улсын язгуур эрх ашиг, иргэний сурч, боловсрох, эрхтэй нийцнэ.

Хуулийн төсөлтэй холбогдуулан хууль шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл боловсруулахгүй болно.

Конвенцод нэгдсэнээр гишүүнчлэлийн хураамж болон бусад зардал гарахгүй.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

## ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор “Алсын хараа- 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлагдаж, хүний хөгжил төвтэй хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж байна.

Энэ бодлогын хэрэгжилтийг хангах зорилгоор Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” болон 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т олон улсад өрсөлдөх чадвартай боловсролын хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлэх зорилтыг тус тус дэвшүүлсэн.

Зорилтын хүрээнд хэрэгжилтийг хангахад боловсрол, сургалт, эрдмийн зэрэг, цолыг дэлхийн улсуудтай харилцан хүлээн зөвшөөрөх явдал нэн чухал байна.

Анх 1975 оны 6 дугаар сард Латин Америк болон Карибд дээд боловсролын сургалт, диплом, эрдмийн зэрэг, цолыг хүлээн зөвшөөрөх тухай бүс нутгийн конвенцыг баталснаар дээд боловсролын сургалт болон эрдмийн зэрэг, цолыг харилцан хүлээн зөвшөөрөх үйл ажиллагааг зохицуулах хэм хэмжээг тодорхойлсон бөгөөд үүнээс хойш дэлхийн бүх бүс нутгийг хамруулсан ижил төрлийн 11 Конвенцыг баталсан байна.

“Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенц” нь 2019 оны 11 дүгээр сард ЮНЕСКО-ийн Ерөнхий бага хурлын 40 дүгээр чуулганаар батлагдсан нь Нэгдсэн Үндэстний Байгууллагаас дээд боловсролын салбарыг хамарсан анхны дэлхийн хэмжээний гэрээ болсон байна.

Уг конвенцод нэгдэх нь ЮНЕСКО-ийн гишүүн орнуудад нээлттэй.

Конвенцын XVIII дахь хэсэгт заасны дагуу 2022 оны 12 дугаар сарын 20-нд 20 дахь орон уг конвенцыг соёрхон баталснаар 2023 оны 03 дугаар сарын 05-нд дэлхийн гэрээ хүчин төгөлдөр болсон.

2023 оны 05 дугаар сарын байдлаар Япон, Франц, Норвег, Швед, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс, Австрали, Эстони, Литва, Армени зэрэг дэлхийн 22 улс<sup>1</sup> энэ гэрээнд нэгдэн ороод байна.

Уг конвенц нь нэгдэн орсон улс орнуудын их, дээд сургуулиудын боловсрол, сургалтын үр дүн, зэрэг, цолыг ил тод, шударгаар хүлээн зөвшөөрөх, суралцагчдад бусад орны их, дээд сургуулиудад үргэлжлүүлэн суралцах, хөдөлмөр эрхлэх, зайн хэлбэрээр суралцах, эзэмшсэн мэргэшлээ хүлээн зөвшөөрүүлэх боломжийг олгодог.

“Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенц” нь дараахь харилцааг зохицуулахад чиглэсэн байна:

1. дээд боловсролын чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжиж, бэхжүүлэх;

2. дээд боловсролын чиглэлээрх олон улсын хамтын ажиллагааны зорилгоор бүс нутаг хоорондын санал санаачилга, бодлого, инновацыг дэмжих;

3. улс, орнуудын дээд боловсролын тогтолцооны ялгаатай байдлыг ойлгож, хүндлэхийн зэрэгцээ дээд боловсролын эрдмийн зэрэг эзэмшигчид, дээд боловсролын байгууллагууд, ажил олгогчид, бусад оролцогч талд харилцан ашигтай

<sup>1</sup> <https://www.unesco.org/en/higher-education/global-convention>

байлгах, дэлхий дахинд дээд боловсролын салбар дахь шилжилт хөдөлгөөн болон ололт амжилтыг дэмжих;

4.дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг шударга, ил тод, тууштай, уялдаатай, цаг үеэ олсон, найдвартай хүлээн зөвшөөрөх зорилгоор дэлхий нийтийг хамарсан хүртээмжтэй тогтолцоог бий болгох;

5.дээд боловсролын байгууллага болон тогтолцооны бие даасан бөгөөд ялгаатай байдлыг хүндэтгэж, дэмжиж, хамгаалах;

6.шударга байдал, ёс зүйн хэм хэмжээг хөхиүлэн дэмжих замаар эрдмийн зэргийн чанар, найдвартай байдалд итгэх итгэл, үнэмшлийг дээшлүүлэх;

7.олон улсын шилжилт хөдөлгөөнийг дэмжих зорилгоор эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөхөд дээд боловсролын тогтолцоонд чанарын баталгаажуулалтын соёлыг хөхиүлэн дэмжиж, найдвартай, уялдаа холбоотой, харилцан нөхөхүйц байхад шаардлагатай чадавхыг хөгжүүлэх;

8.улс орон, бүс нутгийн хооронд хүртээмжтэй, орчин үеийн, найдвартай, ил тод, холбогдол бүхий мэдээлэл боловсруулах, цуглуулах, солилцох, мөн шилдэг туршлагыг түгээх үйл явцыг хөхиүлэн дэмжих;

9.эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх замаар чанартай дээд боловсролыг тэгш, хүртээмжтэй эзэмших боломжийг хөхиүлэн дэмжих, дүрвэгсэд ба шилжин суурьшсан этгээдийг оролцуулан бүх хүнд насан туршийн сургалтын боломжийг бүрдүүлэн дэмжих;

10.тогтвортой хөгжлийн төлөө боловсролыг дэмжих үүднээс хүний болон боловсролын нөөцийг оновчтой ашиглахыг хөхиүлэн дэмжиж, зохион байгуулалтын бүтэц, эдийн засаг, технологи, соёл, ардчилал, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах зэрэг болно.

“Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенц” нь дор дурдсан зарчмыг баримтлахаар заасан байна:

1.хувь хүний дээд боловсрол эзэмших өргөдөл гаргах, эсхүл ажил хөдөлмөр эрхлэх зорилгоор өөрийн боловсролын зэрэгт үнэлгээ хийлгэх эрх байх;

2.эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх үйл явц нь улс бүрийн дүрэм, журмын дагуу ил тод, шударга, цаг үеэ олсон, алагчлалаас ангид байхаас гадна хямд өртөгтэй байх;

3.хүлээн зөвшөөрөх тухай шийдвэр нь итгэлцэл, тодорхой шалгуур болон шударга, ил тод, алагчлалаас ангид байж, дээд боловсролын тэгш хүртээмжтэй байдал болон хөдөлмөр эрхлэх боломжийг нээсэн нийтийн сайн сайхны төлөө үйл хэрэг чухал болохыг онцолсон байх;

4.хүлээн зөвшөөрөх тухай шийдвэр нь дээд боловсролын тогтолцоо, байгууллага, хөтөлбөр, чанарын баталгаа олгох механизмын талаарх зохистой, найдвартай, хүртээмжтэй, орчин үеийн мэдээлэлд үндэслэж, эдгээр мэдээллийг улс орнуудын эрх бүхий байгууллага, үндэсний албан ёсны мэдээллийн төв, эсхүл тэдгээртэй ижил төстэй байгууллагаас хүлээн авсан байх;

5.хүлээн зөвшөөрөх тухай шийдвэрийг дэлхий дахины дээд боловсролын тогтолцооны ялгаатай байдлыг харгалзан үзсэн байх;

6.хүлээн зөвшөөрөх үнэлгээ хийх эрх бүхий байгууллага нь шийдвэрийг шударгаар гаргаж, шийдвэрийнхээ үндэслэлийг тодорхой тайлбарлан, шийдвэрт гомдол гаргах зохицуулалтыг тогтоосон байх;

7.эрдмийн зэргээ хүлээн зөвшөөрүүлэхээр өргөдөл гаргагч нь эзэмшсэн эрдмийн зэргийнхээ талаар зохих ёсны, үнэн зөв мэдээлэл, бичиг баримтыг шударгаар бүрдүүлж өгч, холбогдох шийдвэрийн талаар гомдол гаргах эрхтэй байх;

8.оролцогч улс орнуудын хооронд орчин үеийн технологи болон мэдээлэл солилцох сүлжээг ашиглахыг дэмжиж, дээд боловсролын эрдмийн зэрэгтэй холбоотой бүх хэлбэрийн хууран мэхлэх үйлдлийг устгах арга хэмжээ авах үүрэг хүлээх зэрэг.

Нэгдсэн Үндэсний Байгууллагын албан ёсны 6 хэл болох англи, араб, испани, орос, франц, хятад хэлээр гарсан “Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенц”-д “Боломж” (дээд боловсрол эзэмших), “Элсэлт” (дээд боловсролын байгууллага ба хөтөлбөрийн), “Өргөдөл гаргагч”, “Үнэлгээ”, “Эрх бүхий байгууллага”, “Хүлээн зөвшөөрөх эрх бүхий байгууллага”, “Засаг захиргааны нэгж”, “Хил дамнасан боловсрол”, “Шилжин суурьшсан этгээд”, “Албан боловсролын тогтолцоо”, “Албан сургалт”, “Дээд боловсрол”, “Дээд боловсролын байгууллага”, “Дээд боловсролын хөтөлбөр”, “Албан бус сургалт”, “Олон улсын хамтарсан зэрэг”, “Сургалтын үр дүн”, “Насан туршийн сургалт”, “Шилжилт хөдөлгөөн”, “Сургалтын уламжлалт бус арга”, “Хэсэгчлэн хүлээн зөвшөөрөх”, “Хэсэгчилсэн сургалт”, “Өмнөх сургалт”, “Эрдмийн зэрэг”, “Шаардлага хангасан өргөдөл гаргагч”, “Эрдмийн зэргийн хүрээ”, “Чанарын баталгаажуулалт”, “Хүлээн зөвшөөрөх”, “Бүс нутаг”, “Хүлээн зөвшөөрөх тухай бүс нутгийн конвенц”, “Тавигдах шаардлага (Ерөнхий болон тусгай шаардлага)”, “Үлэмж ялгаа” зэрэг нэр томъёоны тодорхойлолтын утгыг зааж өгсөн.

Конвенц нь 25 зүйл бүхий зургаан бүлгээр дараахь харилцааг зохицуулсан байна:

-Нэгдүгээр бүлэгт дээд боловсролын нэр томъёоны тодорхойлолт;

-Хоёрдугаар бүлэгт конвенцын зорилго;

-Гуравдугаар бүлэгт дээд боловсролын эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх үндсэн зарчим;

-Дөрөвдүгээр бүлэгт конвенцын гишүүн улсын үүрэг;

-Тавдугаар бүлэгт хэрэгжүүлэх бүтэц ба хамтын ажиллагаа;

-Зургаадугаар бүлэгт гишүүн улсууд соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, конвенцод нэгдэх, хүчин төгөлдөр болох, конвенцын гишүүн улсууд болон Дээд боловсролын эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай бүс нутгийн конвенц, бусад гэрээ хэлэлцээрийн талуудын хоорондын харилцаа, холбооны, эсвэл нэгдмэл бус үндсэн хуультай тогтолцоо, конвенцоос гарах, эх хадгалагчийн чиг үүрэг, конвенцод нэмэлт өөрчлөлт оруулах харилцаа, Нэгдсэн Үндэстний Байгууллагад бүртгүүлэх, албан ёсны эх хувийг тодорхойлох зэрэг харилцааг багтаасан байна.

Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг Боловсрол, шинжлэх ухааны яамнаас Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдөр танилцуулж, хуралдааны 52 дугаар тэмдэглэлд заасны дагуу Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр тогтсон.

Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын Байнгын хорооны 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг зөвшилцөх асуудлыг дэмжсэн.

Иймд “Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг соёрхон батлах тухай хууль”-ийн төслийг Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, хурадааны 33 дугаар тэмдэглэлээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтсон байна.

“Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенц”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл нь “1 дүгээр зүйл. Дээд

боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.” гэсэн нэг зүйлтэй.

Хуулийн төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засаг, хууль эрх зүйн сөрөг үр дагавар үүсэхгүй бөгөөд конвенцод нэгдэн ороход эдийн засгийн ямар нэг үр дагавар, нөлөө байхгүй. Уг конвенцод нэгдэн орж, хэрэгжүүлэхэд ямар нэг төлбөр шаардахгүй юм.

ЮНЕСКО-гийн гишүүн улс энэ конвенцыг өөрсдийн үндсэн хуулийн болон хууль тогтоомжийн холбогдох журмын дагуу баталж, соёрхон баталсан тухай баримт бичгийг ЮНЕСКО-ийн Ерөнхий захиралд хадгалуулах тул гарын үсэг зурах шаардлага байхгүй болно.

Хуулийн төсийг баталж, конвенцод нэгдэн орсны дараа Боловсрол, шинжлэх ухааны яамнаас дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллана:

1. Конвенцыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг хангана;

2. Боловсролын ерөнхий хуулийн хэрэгжилтийн хүрээнд дээд боловсролын тогтолцоо, эрдмийн зэрэг, чанарын баталгаажуулалт, эрдмийн зэргийн цар хүрээний тухай холбогдох үнэн зөв мэдээллийг хүртээмжтэй байлгах үүднээс магадлан итгэмжлэл хийх эрхийг дотоодын байгууллагад олгох, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 7.9-д заасны дагуу гадаадын хуулийн этгээдэд зөвшөөрөл олгох, гадаад улсын болон олон улсын эрх бүхий байгууллагатай хамтран магадлан итгэмжлэл хийх, олон улсад магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийг баталгаажуулах, бүртгэх үйл ажиллагааг Боловсролын чанарын баталгаажуулалт магадлан итгэмжлэлийн байгууллага хэрэгжүүлж, олон улсын гэрээ, хэлэлцээрийн хүрээнд боловсролын зэрэг, баримт бичгийг харилцан хүлээн зөвшөөрөх, судалгаа, үнэлгээ хийх, баталгаажуулах сан бүрдүүлнэ;

3. Монгол Улс, Засгийн газар хоорондын Бага хурлын сүлжээнд нэгдэж, бүс нутгийн хороодтой хамтран ажиллана.

Конвенцод нэгдэн орсноор дээд боловсролын салбар дахь олон улсын харилцан ашигтай хамтын ажиллагаа бэхжиж, бүс нутаг хоорондын санал, бодлого, инновац дэмжигдэх, дээд боловсролын байгууллага, тогтолцоонд чанарын баталгаажуулалтын тогтолцоо, соёл төлөвших, чанарын баталгаажуулалт найдвартай, уялдаа холбоо, чадавх бэхжих болно.

Түүнчлэн дээд боловсролын мэргэшлийг шударга, ил тод, ялгаварлан гадуурхалгүйгээр хүлээн зөвшөөрч, дээд боловсрол эзэмших боломжийг олгож, цаашдын суралцах, ажилд орох боломжийг олгодог нийтлэг зарчмууд хэрэгжинэ.

Мөн зайны сургалтаар олж авсан иргэний мэргэшил, өмнө нь суралцсан, суралцах хугацааг хүлээн зөвшөөрөх, иргэд насан туршийн боловсрол, сургалтад хамрагдах боломж бүрдэнэ.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Олон улсын гэрээний тухай хууль, Боловсролын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/, Дээд боловсролын тухай хууль /шинэчилсэн найруулга/, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал болон бусад хуульд заасан Монгол Улсын язгуур эрх ашиг, иргэний сурч, боловсрох, эрхтэй нийцнэ.

Хуулийн төсөлтэй холбогдуулан хууль шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл боловсруулахгүй болно.

Конвенцод нэгдсэнээр гишүүнчлэлийн хураамж болон бусад зардал гарахгүй.

МОНГО УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР